



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

### Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Иргэний хуулийн 111 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 32.8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Багануурын зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Капитал банкин дахь нийт 29,289,747.50 (хорин есөн сая хоёр зуун наян есөн мянга долоон зуун дөчин долоон төгрөг тавин мөнгө) төгрөгийн харилцах дансны авлагад тооцон тус банкны эрх хүлээн авагчаас санал болгож хүлээн авахаар тохиролцсон 38,0000,000.00 (гучин найман сая) төгрөгийн үнэлгээ бүхий 97-50 УБМ улсын дугаартай, Тоёота Камири маркийн хавсралтад заасан автомашиныг тус компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Багануурын зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захиралын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Шүрэнчулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах,

2.2.Автомашины улсын дугаарыг шилжүүлэн авч арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

2.3.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



13201001

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн  
67 дугаар тогтоолын хавсралт

**"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН  
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| Д/д      | Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар   | Үйлдвэрлэсэн /Ашиглалтанд орсон он | Тоо хэмжээ (ш) | Балансын үнэ (төгрөг) |
|----------|---|------------------------------------|----------------|-----------------------|
| 1        | Тоёота Камри, 97-50 УБМ,<br>4T1BF1FKXHU291046 | 2016/2019                          | 1              | 38,000,000.00         |
| Нийт дүн |   |                                    |                | 38,000,000.00         |
|          |   |                                    |                | (гучин найман сая)    |